



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 17-дээр

Дугаар 40

Мандалговь


Г- Хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.а дахь заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 18,600,000 /арван найман сая зургаан зуун мянган/ төгрөгний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Тоёота Прадо маркын автомашиныг худалдах үнийн доод хязгаарыг 6,000,000 /зургаан сая/ төгрөгөөр тогтоон дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохих журмын дагуу зохион байгуулж хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Уганбаяр/-т үүрэг болгосугай.
3. Эд хөрөнгийг худалдагдсаны дараа зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Аймгийн засаг даргын тамгын газар /О.Чулуунбат/-т даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Уганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР



0100103